



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 39

Арвайхээр


Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 -ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Адил боломж" аймгийн хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, зарцуулагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн
29 тогтоолын нэгдүгээр хавсралт

“АДИЛ БОЛОМЖ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүүхдийн эрхийн конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай халамж болон ижил тэгш харьцааг хүлээн авах эрхтэй” хэмээн заасан байдаг. Монгол улс энэхүү конвенцид нэгдэн орсныхоо хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөлийг нь хүүхэд бүрийн онцлогт тохирсноор хангах үүргийг хүлээдэг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусдын адил идэвхтэй иргэн болгон төлөвлүүлэхтэй холбогдон гарч буй бусад олон улсын баримт бичгүүд, тухайлбал “Ази номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” 2013-2022 оны Инчеоны стратеги, ДЭМБ, ОУХБ, ЮНЕСКО байгууллагуудын хамтран боловсруулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд нь түшиглэн сэргээн засах удирдамж, Сэргээн засалт 2030 зэрэг баримт бичгүүд, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Нийгмийн бодлого” буюу гуравдугаар бүлгийн 3.3.29-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна; 3.3.30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ” гэсэн заалтуудыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд энэхүү аймгийн хөтөлбөр хувь нэмрээ оруулах болно.

Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэх нь гол төлөв бага насанд илэрдэг боловч зөв оношлох, эмчлэх, улмаар тэднийг нийгэмшүүлэх, сургах асуудал зөвхөн эцэг эхийн үүрэг байж, төрийн оролцоо дутагдсаар ирсэн байна.

2017 оны 3 дугаар сарын байдлаар манай аймагт хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны 423 хүүхэд байна. /ХХҮГазрын судалгаагаар/. Тэдгээрээс 47 хүүхэд харааны, 53 хүүхэд сонсгол, хэл ярианы, 63 хүүхэд сэтгэцийн, 72 хүүхэд оюун ухааны, 92 хүүхэд хөдөлгөөний, 94 хүүхэд бусад буюу хавсарсан бэрхшээлтэй байна. Мөн ерөнхий боловсролын сургуульд 153, цэцэрлэгт 27 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байгаа бол байнгын асаргаанд гэртээ 243 хүүхэд байдаг гэсэн статистик судалгаа гарсан байна.

Манай аймгийн хувьд Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай ангийг 2001 онд анх нээснээс хойш 17 дахь жилдээ нийт 126 хүүхдийг бага, суурь боловсрол

эзэмшүүлсэн бол одоогийн байдлаар 2 дугаар сургуулийн дэргэдэх тусгай ангид 21 ХБ-тэй хүүхэд, 3 дугаар цэцэрлэг дээр 2015 оноос 1 бүлэг нээж, одоогоор 7 ХБ-тэй хүүхдийг, хүүхэд харах үйлчилгээгээр 11 ХБ-тэй хүүхдийг эрүүл хүүхдүүдийн хамтаар сургаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдийн дэргэд бүлэг нээн сургаснаар тэд бага, суурь боловсролыг бүрэн эзэмшихээс гадна онцлог давуу тал, авъяасыг нь нээн илрүүлж, хөгжүүлэн тодорхой үр дүнд хүрч байгаагийн олон бодит жишээг дурдаж болно.

Манай аймагт хөгжлийн бэрхшээлтэй хэмээн оношлогдон улсаас өгдөг халамжийн үйлчилгээнээс өөр нийгмийн үйлчилээг хүртэж чадахгүй гэрийн асаргаанд амьдарч байгаа тэдгээр хүүхдүүдийг тогтмол, мэргэжлийн түвшний нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах орчин нөхцөл бүрдээгүй байна.

Тиймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх төвтөй болох, сэтгэл санааны хувьд өөрийгөө жолоодох, ирээдүйд итгэх, хүн хүнээ хүндэтгэх зэрэг зөв чиг хандлагатай болгож төлөвшүүлэх, аливаа асуудалд биечлэн оролцуулах, идэвхтэй амьдрах нийгмийн хэрэгцээ, шаардлага байгаа төдийгүй тэднийг нийгэм, хамт олонд нь түшиглэн сургаж, хөгжүүлэх, гадуурхан хайхрамжгүй ханддаг байдлыг арилгах, нийгмийн хөгжлийн явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аж байдлыг сайжруулах үйл хэрэгт эцэг эх, нийгэм, хамт олны хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх, цогц, тогтвортой ажиллагаа, зохицуулалтыг хангасан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг эрүүл хүүхдийн адил тэгш хөгжүүлэх, оролцуулах боломжоор хангах

Гурав. Зорилт

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, нөхөн сэргээх эмчилгээ хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, авъяас, ур чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн үйлчилгээг сайжруулан, тэдний төлөө ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах

Дөрөв. Үйл ажиллагаа.

Зорилт 1-ийн хүрээнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээний төвийг байгуулах

- Сэргээн засах чиглэлээр эмч мэргэжилтнүүд, сайн дурынхныг үе шаттайгаар сургаж бэлтгэх
- Хүүхдийг нярай үед нь хөгжлийн бэрхшээлийг нь оношлох боломж бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үзлэг оношлогоог хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах

Зорилт 2-ын хүрээнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд сурах боломж, нөхцөлийг хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах багш нарыг тусгай сургалтанд хамруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд болон бусад сурагчид боловсролын байгууллагын үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтын үйл ажиллагаа
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах үйл ажиллагаа
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багшид цалингийн нэмэгдэл олгох асуудал

Зорилт 3-ын хүрээнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлэх ажил
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр ажиллах ТББ-уудыг байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, дэмжих чиглэлийн арга хэмжээ

Тав. Хугацаа

2017-2021 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр байна.

Зургаа. Үр дүн, шалгуур үзүүлэлт.

6.1. Үр дүн

6.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, нөхөн сэргээх эмчилгээ хийх орчин нөхцөл бүрдсэн байна.

6.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, авъяас, ур чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох идэвхтэй оролцоо нэмэгдэж, ХБХ-тэй

ажиллах багш нарын арга зүй дээшилж, тэднийг хайрлах, дэмжих олон нийтийн хандлага сайжирсан байна.

6.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмж нэмэгдэж, тэдний төлөө үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллага байгуулагдан, холбогдох төрийн байгууллагуудын бодлого чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлтөнд ХБХ-ийн талаар зорилт арга хэмжээ тусгадаг болсон байна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах үзүүлэлтээр үнэлнэ.

6.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээний төв байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон эсэх

6.2.2. Хөдөлгөөн засалч, хэл яриа засалч гэх мэт нөхөн сэргээх чиглэлээр сургалтанд хамрагдан, эмчилгээ, үйлчилгээ үзүүлж буй ажилтан, эмчийн тоо

6.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношлогоо, эмчилгээний багаж, хэрэгслийг худалдан авахад зарцуулсан хөрөнгийн дүн

6.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах тусгай сургалтанд хамрагдсан багш нарын тоо

6.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын орчныг сайжруулахад зарцуулсан хөрөнгө оруулалтын дүн

6.2.6. Бүс нутаг, улс, тив, дэлхийн хэмжээнд амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амжилтын үзүүлэлт

6.2.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтцийн хувь хэмжээ

6.2.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр байгуулагдсан ТББ-ын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалтын дүн зэрэг үзүүлэлтээр тус хөтөлбөрийн биелэлтийг хэмжинэ.

Долоо. Удирдлага, зохион байгуулалт

7.1. Тус хөтөлбөрийн үйл ажиллагаанд бүх салбарын оролцоог хангах, хамтын ажиллагааг зохицуулах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сумдын ЗДТГазар, ерөнхий боловсролын сургуулиуд, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд болон бусад төрийн байгууллагууд гүйцэтгэнэ.

7.3. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг сумдын ЗДТГазар мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

7.4. Орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх холбогдох агентлагууд аймгийн Засаг даргын тамгын газарт жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны дотор жилд 1 удаа тайлагнана.

7.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнаж байна.

---oo0oo---

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 07 дүгээр сарын 29-ны өдрийн
29 тоот тоолын хоёрдугаар хавсралт

ИТХА0019

**“АДИЛ БОЛОМЖ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Санхүүжилтийн эх үүсвэр
Зорилт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, нөхөн сэргээх эмчилгээ хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх				Үр дүн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, нөхөн сэргээх эмчилгээ хийх орчин нөхцөл бүрдсэн байна.	
1.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээний төвийг байгуулах	2018	Аймгийн ЗДТГ	ОУ-ын байгууллага,	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
1.2	Сэргээн засах /хөдөлгөөн, хэл яриа засалч, дохионы хэл г.м/ чиглэлээр сумдын болон өрхийн эмч мэргэжилтнүүдийг үе шаттайгаар сургаж бэлтгэх	2018-2019	ЭМГ	БОЭТ Сумдын ЭМТ ОУ-ын байгууллага	Улс орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
1.3	БОЭТ-ийн ЭНЧХХ-н тасгийн чих, хамар, хоолойн амбулаторийг бага насны хүүхдийн сонсголын бичлэгийн аппарат, дунд чихний дурангаар хангаж, орон нутагт сонсголын бууралтыг оношлох нөхцөл боломжийг бүрдүүлэх	2019-2021	Аймгийн ЗДТГ ЭМГ	БОЭТ	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
1.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, сэргээн засах тусламж үйлчилгээний асуудлыг	2017-2021	Сум, өрхийн ЭМТ	ЭМГ, БОЭТ ХУВИЙН ХЭВШЛИЙН	Улс орон нутгийн төсөв

				ЭМНЭЛГҮҮД	
	шийдвэрлэх, хавсарсан эмгэгийг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх				
1.5	Жирэмсний үеийн хяналтыг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, осол гэмтэл, цус ойртолтоос сэргийлэх талаар иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2017-2021	Сум, өрхийн ЭМТ	ЦГ, БОЭТ, сум, өрхийн ЭМТ	Улс, орон нутгийн төсөв
1.6	Хүүхдийн түнхний мултрал болон харааны бэрхшээлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгааг хийх, энэ төрлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог бууруулах чиглэлээр сумдын НЭМТ-үүдтэй хамтран ажиллах	2017-2021	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	Улс, орон нутгийн төсөв
1.7	Сургуулийн эмч, цэцэрлэгийн багш нарт хөдөлгөөн заслын чиглэлээр сургалт зохион байгуулж, эрүүл хүүхдүүдийн дунд сурч буй ХБХ-үүдэд хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн сургалт тогтмол зохион байгуулах боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн зохицуулалт хийх	2018	ЭМГ	БУСГазар ЕБС, цэцэрлэгүүд	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
1.8	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд хүүхдээ олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, хэвлийд байхаас нь эхлэн хамгаалах талаар сургалт зохион байгуулах	2017-2021	ЭМГ Сум, өрхийн ЭМТ	Төрийн болон төрийн бус байгууллагууд	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
1.9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах	2017-2021	Аймгийн ЗДТГ	Аймгийн ЗД-ын дэргэдэх ХХҮГ, БСУГ БОЭТ	Улсын төсөв
1.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр Франц-Монголын хамтын ажиллагааны нийгэмдэгтэй хамтран ажиллах	2017-2021	Аймгийн ЗДТГ	Эрүүл мэндийн байгууллагууд	ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр

Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, авъяас, ур чадвараа хөгжүүлэх, нигмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх				Үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, авъяас, ур чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох идэвхтэй оролцоо нэмэгдэж, ХБХ-тэй ажиллах багш нарын арга зүй дээшилж, тэднийг хайрлах, дэмжих олон нийтийн хандлага сайжирсан байна.	
2.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах, 1-2 цэцэрлэг дээр бүлэг нээж ажиллуулах	2019-2021	БСУГазар	СӨБ-ын байгууллага	Улсын төсөв
2.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах 10 багшийг /цэцэрлэгийн багш, бага ангийн, дуу хөгжмийн, биеийн тамирын/ тусгай сургалтанд хамруулж, бэлтгэх	2019-2021	БСУГазар	ЕБСургуулиуд	Орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.3	Арвайхээр сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн дэргэдэх тусгай бүлгийн сургалтын орчныг сайжруулах, тохижилтыг хийх, цахим орчиноор хангах, компьютержүүлэх	2017-2021	Аймгийн ЗДТГ	ЕБ-ын 2 дугаар сургууль	Орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулах, аймгийн МСҮТ-д элсүүлэх	2017-2021	МСҮТөв	ЕБ-ын 2 дугаар сургууль	Улсын төсөв
2.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, сургалтын техник хэрэгслийг нэмэгдүүлэх	2017-2021	Аймгийн ЗДТГ	ЕБ-ын 2 дугаар сургууль ОУ-ын байгууллага	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд биеийн тамирын хичээл орох тоног төхөөрөмжтэй болох /Арвайхээр-1, Баян-Өндөр, Богд, Хархорин-1,2, Хужирт, Бат-Өлзий, Өлзийт/	2017-2021	Аймгийн ЗДТГ	ЕБ-ын 2 дугаар сургууль ОУ-ын байгууллага	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр

2.7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай ангийн дэргэд харааны бэрхшээлтэй хүүхдүүд болон иргэдэд зориулсан мэдээллийн танхимтай болох	2017-2018	БСУГ	ОУ-ын байгууллага Данийн төсөл	ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд ХБ-тэй хүүхдээ хэрхэн хөгжүүлэх, харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах,	2017-2021	ГБХЗХГазар БСУГазар	ОУ-ын байгууллага	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.9	ХБХ-ийг сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичгээр шат дараатай хангах	2017-2021	БСУГазар	ЕБ-ын 2 дугаар сургууль ОУ-ын байгууллага	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.10	Сургуулийн нийгмийн ажилтан, номын санч болон бусад үйлчилгээний ажилтнуудад ХБХ-тэй ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулах,	2018-2019	БСУГазар	ГБХЗХГазар ОУ-ын байгууллага	Орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.11	ЕБС-ийн захирал, СӨББ-ын эрхлэгч нарын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд ХБХ-тэй ажиллах талаар заалт тусган хэрэгжүүлэх	2018-2021	БСУГазар	ЕБС СӨББ	=
2.12	ХБХ-ийн сургалтын хоцрогдлыг нөхөх сургалтыг үе шаттай зохион байгуулах	2017-2021	ЕБС, СӨББ-ууд	БСУГ	Улсын төсөв
2.13	Төрөл бүрийн дугуйлан секцүүдэд ХБХ-үүдийг эрүүл хүүхдүүдийн хамтаар хамруулах	2017-2021	ЕБС, СӨББ-ууд	ГБХЗХГазар БСУГазар	Улсын төсөв
2.14	Аймгийн ХБХ-ийн спортын нэгдсэн арга хэмжээ, бусад төрлийн уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах	2017-2021	БТСГазар	ГБХЗХГазар БСУГазар	Орон нутгийн төсөв
2.15	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн, урлагийн тоглолт зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлах	2017-2021	ГБХЗХГазар	БСУГазар	Орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.16	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аймаг, улс, олон улсын тэмцээн уралдаанд ороход	2017-2021	Аймаг, сумдын ЗДТГ	ГБХЗХГазар БСУГазар ОУ-ыг байгууллага	Орон нутгийн төсөв

	дэмжлэг үзүүлэх				
2.17	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн авьяас чадвар, амжилтыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах	2017-2018	Аймгийн ЗД-ын дэргэдэх ГБХЗХГазар	БСУГазар	Орон нутгийн төсөв
2.18	Хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийнхэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилтот төсөл, болзолт уралдааныг ХӨУБ-уудын дунд зохион байгуулах	2017-2021	ГБХЗХГазар БСУГазар	ЕБС-иуд	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.19	Аймгийн Засаг даргын ивээл дор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Төвийн бүсийн Зуны спорт, урлагийн наадам зохион байгуулах	2019	Аймгийн ЗДТГ	Аймгийн ЗД-ын дэргэдэх БСУГ, ГБХЗХГ	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
2.20	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид хуулинд заасан цалингийн нэмэгдлийг хүүхдийн тооноос хамаарч, цалингийн санд багтаан олгох	2018-2021	БСУГазар	ЕБС, СӨББ-ууд	Улсын төсөв
2.21	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт нийцсэн хэлбэрээр мэдээлэл, өгөх, санал бодлыг нь хүлээн авах зорилгоор тэдэнд зориулсан хялбаршуулсан ном, гарын авлагыг бэлтгэн гаргах	2017-2021	ГБХЗХГазар	БСУГазар	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
Зорилт3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн үйлчилгээг сайжруулан, тэдний төлөө ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах				Үр дүн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмж нэмэгдэж, тэдний төлөө үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллага байгуулагдан, холбогдох төрийн байгуулагуудын бодлого чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлтөнд ХБХ-ийн талаар зорилт арга хэмжээ тусгадаг болсон байна.	
3.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, дүгнэлт хийх	2017-2021	ХХҮГазар	ГБХЗХГазар, БСУГ, ЭМГ	

3.2	Төрийн болон төрийн бус бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан орох, гарах гарцыг бий болгох	2017-2021	Аймгийн ЗДТГ	Төрийн болон төрийн бус бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд	Улсын төсөв Хувийн хэвшлийн хөрөнгө
3.3	Аймгийн ХДТ-ын үзвэрийн 5-10 сандалыг ХБХ-д зориулан, стандартын дагуу болгох	2017-2021	Аймгийн ХДТ		Улс, орон нутгийн төсөв
3.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, бүлэг байгуулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2018-2019	ТББАймгийн ЗДТГ	=	Орон нутгийн төсөв
3.5	ХБХ-ийн хүүхдийн хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулж, тус цэцэрлэгт хөдөлгөөн засалч ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	2017-2021	Аймгийн ЗДТГ	БСУГ	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр Хувийн хэвшлийн хөрөнгө
3.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг Олон Нийтийн Оролцоонд Түшиглэсэн Халамжийн үйлчилгээнийн хүрээнд сэргээн засах үйлчилгээнд хамруулах	2017-2021	ХХҮГазар	Хувийн эмнэлгүүд	Улсын төсөв
3.7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн протез хийлгэх болон ортопедийн хэрэгсэл хийлгэхэд дэмжлэг үзүүлэх	2017-2021	ХХҮГазар		Улсын төсөв
3.8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт Нийгмийн халамжийн тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, гарын авлага, материалаар хангах	2017-2021	ХХҮГазар	БСУГ ГБХЗХГ	Улс, орон нутгийн төсөв ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр

3.9	Тусгай хэрэгцээт боловсрол, сэргээн засалтын чиглэлээр "Жайка" олон улсын байгууллагын сайн дурын ажилтныг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ажиллуулах	2017-2019	Аймгийн ЗДТГазар		ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр
-----	--	-----------	------------------	--	------------------------------------

---oo0oo---